

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

АУДИТЫН КОД: СЭА-2021/03-ШТА-ГА

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 65.8 хувь нь бүрэн, 9.2 хувь нь дутуу хэрэгжсэн бол 25.0 хувь нь огт хэрэгжээгүй байна.

Сүхбаатар хот 2021 он

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор С.Баасансүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: baasansurens@audit.gov.mn

Аудитор Ж.Цогт

Утас: 70363036 Цахим хаяг: tsogtj@audit.gov.mn

Аудитор Т.Мөнхзул

Утас: 70363036 Цахим хаяг: munkhzult@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
Дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
С.Баасансүрэн

Аудитор
Ж.Цогт
Т.Мөнхзул

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл гарвал
70362442, 70363047,
70363040 дугаарын
утас,
Selenge@audit.gov.mn
цахим сайтаар
харилцана уу.

Хаяг: Сэлэнгэ аймаг,
Сүхбаатар сум, аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

2021 оны 05-07 дугаар
сар

Товчилсон үгийн тайлбар
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Үндсэн мэдээлэл

Бүлэг 1. ОНХС-ийн хөрөнгийг холбогдох эх үүсвэрээс бүрэн бүрдүүлж, үр нөлөө, үр ашигтай байхаар төлөвлөж, хуваарилсан уу.

1.1 Түшиг сумаас бусад сумд нь ОНХС-ийн эх үүсвэрт хандив, тусламжийн орлогыг төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

1.2. ОНХС-ийн хөрөнгийг төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зориулалт бус зардлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа нь нөөцийг үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй зарцуулж, хуваарилах зарчмыг алдагдуулж байна.

Бүлэг 2. ОНХС-ийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу.

2.1 ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль эрхийн актын хүрээнд зохион байгуулахгүй байгаа нь хөрөнгө нөөцийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг алдагдуулж байна.

2.2. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 184 төсөл, арга хэмжээний 25.0 хувь нь огт хэрэгжээгүй бол 9.2 хувь нь дутуу хэрэгжсэн байна.

2.3 Эрх бүхий байгууллагуудаас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд үр нөлөө бүхий хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Илрүүлсэн зөрчил
Дүгнэлт
Зөвлөмж

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НҮТББ	Нийгэмд үйлчлэх Төрийн бус байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрх, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгийг холбогдох эх үүсвэрээс бүрэн бүрдүүлж, үр нөлөө, үр ашигтай байхаар төлөвлөж, хуваарилсан уу.
- ОНХС-ийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлсэн хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналтын баримт материал болон аймаг, сумын Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, Орон нутгийн өмчийн газар, Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн гаргасан Монгол Улсын Төрийн аудитын стандарт / **MNS:6817-1:2020** “Төрийн аудит.Тулгуур зарчим”, **MNS:6817-5:2020** “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, **MNS 6817-7:2020** “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудит” /-д заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, гүйцэтгэлийн аудитын аргачлалыг ашиглан аймаг, сумдын Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүд, Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын хяналтын инженерүүд болон холбогдох бусад албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Аудитын тайлан, дүгнэлтэд дэмжлэг болох судалгааг хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль ,
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль,
- ТБОНӨХБАҮХА тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”, 08 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал” ,
- Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” , 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”, 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”, 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”, 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Дээрх хууль, журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, холбогдох бусад хууль эрхийн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт, Т.Мөнхзул нар 2021 оны 05 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Тайлант онд аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 3,914.0 сая төгрөг, улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг 3,130.1 сая төгрөг, тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгох дэмжлэг, урамшуулал 695.4 / Урамшуулал 400.7 сая төгрөг, дэмжлэг 294.7 сая төгрөг / сая төгрөг, аймаг, сумдын ОНХС-ийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 637.0 / Аймгийн ОНХС-201.4 сая төгрөг, сумдын ОНХС- 435.6 сая төгрөг / сая төгрөг, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжүүдийн хандивын орлого 845.0 сая төгрөг зэрэг нийт **9,221.5 сая** төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд нийт 10,989.3 сая төгрөгийн / аймаг 7,483.2 сая төгрөг, сумд 3,506.1 сая төгрөг / төсөвт өртөгтэй 189 төсөл, арга хэмжээ /Ерөө, Жавхлант, Мандал, Сайхан сумдын өмнөх оноос шилжиж ирсэн 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний 2020 онд

санхүүжих дүн нь 287.8 сая төгрөгөөр зөрүү үүссэн болно/-г хэрэгжүүлэхээс 5,503.0 сая төгрөгийн өртөгтэй 121 төсөл, арга хэмжээ бүрэн, 1,899.3 сая төгрөгийн өртөгтэй 17 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 2,107.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 46 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй, 1,480.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй он дамжин хэрэгжих 5 төсөл, арга хэмжээ байна.

Бүлэг 1

ОНХС-ийн хөрөнгийг холбогдох эх үүсвэрээс бүрэн бүрдүүлж, үр нөлөө, үр ашигтай байхаар төлөвлөж, хуваарилсан уу.

ОНХС-ийн эх үүсвэрт хандив, тусламжийн орлогыг тооцож, төлөвлөөгүй ч ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлгийг аргачлалын дагуу хуваарилсан байна.

1.1. Хөрөнгийн эх үүсвэрийг нөөц боломжийн хүрээнд бүрэн бүрдүүлж, хуваарилсан уу.


Түшиг сумаас бусад сумд нь ОНХС-ийн эх үүсвэрт хандив, тусламжийн орлогыг төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

ОНХНС-аас тайлант онд аймаг, сумдын ОНХС-д 8,141.2 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг хуваарилахаар анх төлөвлөсөн боловч УИХ-аас 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын 2020 оны төсөвт тодотгол хийснээр аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 401.7 сая төгрөгөөр бууруулан 7,739.5 сая төгрөг болгон эцэслэн баталсан байна.

Тайлант онд аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 3,914.0 сая төгрөг, улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг 3,130.1 сая төгрөг, тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгох дэмжлэг, урамшуулал 695.4 сая төгрөг, аймаг, сумдын ОНХС-ийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 637.0 / *Аймгийн ОНХС- 201.4 сая төгрөг, сумдын ОНХС- 435.6 сая төгрөг* / сая төгрөг, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжүүдээс хандив 845.0 сая төгрөг зэрэг нийт **9,221.5 сая** төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнийг графикаар харуулбал:

2020 оны ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэр / төлөвлөсөн /

График 1 /хувиар/



Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор аймгийн ОНХС-д ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Болд төмөр Ерөө гол ХХК-иас 700.0 сая төгрөг, Түшиг сумын ОНХС-д Шар нарст ХХК-иас 140.0 сая төгрөг, Түшиг индустраль ХХК-иас 5.0 сая төгрөг зэрэг нийт 845.0 сая төгрөгийн хандивын орлогыг аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрт төвлөрүүлэхээр төлөвлөж, бүрдүүлсэн байна. / *Аймаг, сумдын ОНХС-ийн нийт эх үүсвэрийг Хавсралт 1-д харуулав* /

Мандал сум нь хамтын ажиллагааны гэрээний дагуу БНСУ-ын Кён бук аймгийн Ы Сон сумаас төвлөрүүлсэн 924.9 сая төгрөгийн хандивын орлогыг “Мандал сумын хөгжлийн төлөө” НҮТББ-ын дансанд, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Бороо гоулд ХХК-ийн 120.0 сая төгрөгийн хандивын орлогыг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.2.5¹ дахь заалтыг зөрчсөн байна.

Дээрхээс үзэхэд аймаг болон Түшиг сумаас бусад сумд нь ОНХС-ийн эх үүсвэрийг зөвхөн ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг, тогтвортой амьжиргаа-3 төслийн дэмжлэг, урамшуулал, ОНХС-ийн оны эхний үлдэгдэл зэргээс бүрдүүлэхээр төлөвлөсөн бол орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор гадаад, дотоодын аж ахуйн нэгжээс өгөх хандив, тусламжийн орлогыг тооцож, төлөвлөөгүй байна.

Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.1², Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8.1³-д заасны дагуу ОНХНС-аас мал эмнэлгийн үйлчилгээнд 319.5 сая төгрөг, усан хангамжид 21.7 сая төгрөг, сумдын хот тохижуулах зардалд 141.3 сая төгрөг зэрэг нийт 482.5 сая төгрөг хуваарилсныг сумдын ОНХС болон холбогдох байгууллагын дансанд зориулалтын дагуу шилжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2⁴, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8.3⁵-т заасны дагуу сумын хүн амын тооноос хамаарах хувийг 40,

¹ 60.2. Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.5. тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

² Аймаг, нийслэл нь ОНХС-аас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум, дүүргийн ОНХС-д хуваарилна: 59.2.1. энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум, дүүргийн ОНХС-д шилжүүлэх.

³ Аймаг, нийслэл нь ОНХНС-аас хуваарилсан орлогын шилжүүлгийг сум, дүүргийн ОНХС-д хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.2-т заасны дагуу дараах байдлаар хуваарилна: 8.1.1. аймаг, нийслэл нь ОНХНС-аас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс Төсвийн тухай хуулийн 59.2.1-д заасны дагуу суурь зардалд ногдох хэсэг (ОНХНС-аас санхүүжихээр батлагдсан суурь зардал)-ийг тухайн сум, дүүргийн ОНХС-д шууд хуваарилна.

⁴ Аймаг, нийслэл нь ОНХС-аас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум, дүүргийн ОНХС-д хуваарилна: 59.2.2. энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах.

⁵ Аймаг, нийслэл нь энэ аргачлалын 8.2-т заасны дагуу хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг дараах байдлаар тооцно: 8.3.1. хүн амын тооноос хамаарах-40 хувь, 8.3.2. алслалтаас хамаарах-30 хувь, 8.3.3. нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах-30 хувь

газар нутгийн алслалтыг 30, нутаг дэвсгэрийн хэмжээг 30 хувь гэсэн 3 итгэлцүүрт үндэслэн дараах байдлаар хуваарилсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт

Хүснэгт 1 /сая төгрөг/

Д/д	Санхүүжилт олгох аймаг, сумд	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан				Тогтвортой амьжиргаа 3 төслөөс		Орлогын шилжүүлгийн дүн	
		Сумын Орон нутгийн хөгжлийн сан			Суурь зарлага	Аймгийн ОНХС	Урам-шуулал		Дэмжлэг
		Хүн ам 40%	Алслалт 30%	Нутаг дэвсгэр 30%					
1	Алтанбулаг	36.9	5.4	30.9			17.2	10.8	101.2
2	Баруунбүрэн	23.3	31.1	41.3			22.2	14.1	132.0
3	Баянгол	41.2	43.6	29.0			26.4	16.7	156.9
4	Ерөө	50.6	27.5	120.5			45.7	28.9	273.2
5	Жавхланта	14.3	5.7	17.5			9.2	5.8	52.5
6	Зүүнбүрэн	21.2	5.7	17.7				6.5	51.1
7	Мандал	200.9	279.8	71.1	77.3		126.8	80.6	836.5
8	Орхон	17.5	18.6	19.2			12.7	8.1	76.1
9	Орхонтуул	27.9	40.6	43.2			25.7	16.3	153.7
10	Сайхан	69.5	67.3	19.3	38.9		36.0	22.8	253.8
11	Сант	15.8	18.2	20.3			12.0	8.1	74.4
12	Сүхбаатар	170.8		0.7	25.1			24.9	221.5
13	Түшиг	13.5	11.1	36.6			12.9	9.3	83.4
14	Хушаат	19.9	10.7	29.5				7.6	67.7
15	Хүдэр	14.9	14.8	41.7			17.9	11.4	100.7
16	Цагааннуур	37.5	20.4	56.0			26.2	16.6	156.7
17	Шаамар	30.1	3.9	9.9			9.8	6.2	59.9
	Сумдын ОНХС	805.8	604.4	604.4	141.3	-	400.7	294.7	2,851.4
18	Аймгийн ОНХС				341.2	4,546.9			4,888.1
	Нийт дүн	805.8	604.4	604.4	482.5	4,546.9	400.7	294.7	7,739.5

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн 2020 оны тайлан, мэдээ

Ингэснээр нийт эх үүсвэрийн 63.1 хувь буюу 4,888.1 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 36.9 хувь буюу 2,851.4 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг үр нөлөө, үр ашигтай байхаар төлөвлөсөн үү.

ОНХС-ийн хөрөнгийг төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зориулалт бус зардлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа нь нөөцийг үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй зарцуулж, хуваарилах зарчмыг алдагдуулж байна.

Сумдын хувьд: Сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэхээр нийт 3,506.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 127 төсөл, арга хэмжээ баталсны 561.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 нь өмнөх оноос шилжсэн бол 2,945.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 108 нь шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ байна.

Дээрх шинээр эхлэх төсөл, арга хэмжээнээс 479.7 сая төгрөгийн 29 төсөл, арга хэмжээний зураг, төсөв, тооцоо судалгааг ИТХ-аар батлуулахаас өмнө хийж, / Нийт 242.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээ нь нохой устгал, зураг төсвийн үнэ, баяр наадмын зардал зэрэг зураг, төсөв шаардлагагүй болно./, 1,477.8 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг батлуулсны дараа хийлгэсэн / Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав / бол 745.2 сая төгрөгийн өртөг бүхий 31 төсөл, арга хэмжээг зураг, төсөв, тооцоо судалгаагүйгээр төлөвлөж, хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 29.4⁶, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3⁷ дахь заалтуудыг зөрчсөн байна.

**Зураг, төсөв, тооцоо судалгаагүйгээр төлөвлөж,
хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ**

Хүснэгт 2 /сая төгрөг/

Д/д	Сумд	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Баруунбүрэн сум	Универсал трактор	65.0
2		Шувуутын голд гүүр тавих	10.0
3		Зам засвар	45.0
4	Ерөө сум	Хогийн цэг цэвэрлэж хашаажуулах / Буурагчин баг/	24.9
5	Жавхлант сум	Сумын төвийг камержуулах	33.1
6	Мандал сум	2 дугаар багт гүний худаг шинээр барьж, ухаалаг худгийн систем суурилуулах	30.0
7		1, 6 дугаар багийн 4 худгийг засварлаж, ухаалаг худгийн систем суурилуулах	80.0
8		Гэрэлтүүлэг засвар	50.0
9	Орхон сум	Хогны машин худалдаж авах	30.0
10	Орхонтуул сум	Рашаант тосгонд явган хүний зам тавих / 200метр /	15.0
11		Баянцогтын 2 дугаар багт 50 тн багтаамж бүхий зоорь барих	45.3
12		Баянцогтын 2 дугаар багт мах нядалгааны цэг барих	53.5
13		Рашаант тосгоны Ахуйн үйлчилгээний барилгын дээврийн засвар	20.0
14	Сайхан сум	Хөтөл хотыг камержуулах	30.0
15	Сүхбаатар сум	8 дугаар багт гүний худаг гаргах	10.0
16		6 дугаар багт гэрэлтүүлгийн ажил	20.0
17		3 дугаар багт гэрэлтүүлгийн ажил	20.0
18	Түшиг сум	Соёлын төвийн хувцас хэрэглэл	10.0
19	Хушаат сум	Даагат 1 дүгээр багийн гудамж талбайн гэрэлтүүлэг	20.0
20		Цагаан идээ боловсруулах цехийн тоног төхөөрөмж худалдан авах	15.0
21	Хүдэр сум	Ерөнхий боловсролын сургуульд А3 өнгөт принтер	2.0
22		Эрүүл мэндийн төвийн биохимийн аппарат	9.0
23		Соёлын төвийн номын сангийн баяжилт	4.0
24		Гудамжны гэрэлтүүлэг засвар	2.0
25		Тээврийн хэрэгслийн зогсоол / журмын хашаа /	5.0
26		Ерөнхий боловсролын сургуулийн гадаад хэлний кабинетын өргөтгөл	8.0
27		Сургуулийн өмнөх боловсролд дэлгэц	0.6
28		Цэцэрлэгийн дунд бүлэгт хүүхдийн тоглоом авах	3.0
29		Дружба уул дахь иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх	55.3

⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

		газрын тохижилт	
30	Цагааннуур сум	Соёлын төвийн үзвэрийн тайзны өмсгөл клүс парталыг шинэчлэх	4.5
31	Шаамар сум	Дэлгэрхаан 1 дүгээр баг Дэнжийн худгийг ухаалаг болгох	25.0
Нийт дүн			745.2

Эх сурвалж: Төсөл, арга хэмжээний зураг, төсөв хийлгэх гэрээ, хүлээн авсан акт

Хэдийгээр сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний дийлэнхийн зураг, төсвийг ИТХ-аар батлуулахын өмнө болон баталсны дараа гүйцэтгэж байгаа боловч уг төсөвт өртөг нь үнэн зөв эсэхэд магадлал хийгддэггүйгээс ижил төстэй төсөл, арга хэмжээг харилцан адилгүй өртгөөр гүйцэтгэсэн буюу эх үүсвэрийг арвилан хэмнэлтгүйгээр зарцуулах нөхцөл болсон байна. Тухайлбал, Жавхлант суманд хэрэгжсэн камержуулалтын төсөл, арга хэмжээ нь Сайхан сумын төсөл, арга хэмжээнээс хүчин чадал, тоо хэмжээний хувьд 2 дахин бага атал өндөр өртгөөр төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

- Сайхан сум нь 360 градусын эргэлттэй 4, 180 градусын эргэлттэй 12 зэрэг нийт 16 камер бүхий “Хөтөл хотыг камержуулах” төсөл, арга хэмжээг 30.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр,
- Жавхлант сум нь 360 градусын эргэлттэй 2, 180 градусын эргэлттэй 6 зэрэг нийт 8 камер бүхий “Сумын төвийг камержуулах” төсөл, арга хэмжээг 33.3 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгүүлсэн.

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг үр нөлөө, үр ашигтай байхаар төлөвлөх зорилгоор Алтанбулаг, Баруунбүрэн, Ерөө, Мандал, Сайхан, Сант, Сүхбаатар, Цагааннуур сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний иргэдээс гаргасан саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд бусад 9 сумдад ажлын хэсэг байгуулаагүйгээс төсөл, арга хэмжээг иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх, орон нутгийн тэргүүлэх чиглэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэхийг нэгтгэн эрэмбэлэх ажил огт хийгдээгүй байна.

2020 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэлгүйгээр Алтанбулаг сум 7.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “ЕБС-ийн ширээ, сандал шинэчлэх”, Цагааннуур сум 4.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Соёлын төвийн үзвэрийн тайзны өмсгөл клүс парталыг шинэчлэх” зэрэг төсөл, арга хэмжээг тусгаж, төлөвлөсөн нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг бууруулж байна.

Төсвийн тухай хуулийн 60.4⁸ дэх заалтыг зөрчиж дараах сумд ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардалд зориулалт бусаар зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Нохой устгалын зардалд Сүхбаатар сум 5.0 сая төгрөг, Хүдэр сум 3.0 сая төгрөг,
- Түшиг сум “Сумын ИТХ-ын тохижилт”-д 3.5 сая төгрөг.

⁸ 60.3 Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй.

Аймгийн хувьд: Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 70 дугаар тогтоолоор 2020 онд ОНХС-ийн эх үүсвэрээр өмнөх оноос шилжиж ирсэн 8, тайлант онд шинээр эхлэх хөрөнгө оруулалт 20, их засварын 12, тоног төхөөрөмж худалдан авах 11, хөтөлбөр, арга хэмжээ */улсын баяр наадам/* 1 зэрэг нийт 52 төсөл, арга хэмжээнд 4,948.6 сая төгрөгийг зарцуулахаар анх баталсан бол 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 73 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын нийт 901.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ */ хөрөнгө оруулалтын 5, Атар 60 жилийн ойн арга хэмжээний зардал /* -г нэмж, нийт 58 төсөл, арга хэмжээнд 5,850.1 сая төгрөгийг зарцуулахаар нэмэгдүүлэн баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 77 дугаар тогтоолоор 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 9.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 57.8 сая төгрөгөөр бууруулж, 116.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг шинээр нэмж нийт 62 хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 5,448.4 сая төгрөгийг зарцуулахаар эцэслэн баталсан байна. Өөрөөр хэлбэл ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг бодит өртөг, тооцоо судалгаан дээр үндэслэн төлөвлөдөггүйгээс удаа дараа төсвийн тодотгол хийх, төсөвт өртгийг өөрчлөх зэрэг зөрчлүүд жил бүр давтагдан гарч байна.

Дээрх тогтоолоор эцэслэн баталсан төсөл, арга хэмжээний жагсаалтад шинээр хэрэгжиж эхлэх 470.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Сайхны хөтлийн шилэн гүүрний суурийн ажил”* төсөл, арга хэмжээний 2020 оны санхүүжилтийг “0” дүнтэйгээр буюу тухайн жил хэрэгжихгүй төсөл арга хэмжээг тусгасан бол нэг төсөл арга хэмжээг буюу Шаамар сумын Партизаны талбайн засварын ажлыг тус бүр 18 сая, 19 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр давхардуулан төлөвлөсөн байна.

Тайлант онд Төсвийн тухай хуулийн 60.3.2⁹, 60.3.3¹⁰ дахь заалтуудыг зөрчиж *“Шагайн холбоонд тоног төхөөрөмж авах”*-д 16.0 сая төгрөгийг, *“Атрын 60 жилийн ойн арга хэмжээний зардал”*-д 120.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймаг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулаагүйгээс сумдаас ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн болон аймгийн хөгжлийн бодлого чиглэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эсэхийг тооцох, урьдчилсан жагсаалтыг эрэмбэлэх, иргэд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажил огт хийгдээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 2,829.5 сая

⁹ 60.3.ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.2.улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага

¹⁰ ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.3. үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал.

төгрөгийн төсөвт өртөг бүхий 31 төсөл, арга хэмжээг тусгасан нь холбогдох хууль, эрхийн актыг зөрчсөнөөс гадна төсөл, арга хэмжээг үр ашиг, үр нөлөөтэйгөөр төлөвлөх нөхцөлийг бууруулж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй
төсөл, арга хэмжээний жагсаалт**

Хүснэгт 3 /сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Нисэх онгоцны зурвас байгуулах	21.6
2	Сүхбаатар сумын орон сууцуудад кодтой хаалга суурилуулах	26.0
3	Сүхбаатар сумын байруудын гэрэлтүүлэг	177.0
4	Сайханы хөтлийн шилэн гүүрний суурийн ажил	470.0
5	Алтанбулаг сумын далангийн ажлын засвар	100.0
6	Баянгол суманд олон улсын авто зам, төмөр замын доогуур бохирын ус зайлуулах шугам байгуулах	80.0
7	Шаамар сумын партизаны талбайн тохижилтын ажил	19.0
8	Шилэн гүүр барих	700.0
9	Мэргэжлийн хяналтын газарт улаан буудайн шинжилгээний аппарат авах	50.0
10	Нэгдсэн эмнэлэгт тархины цахилгаан бичлэгийн аппарат авах	35.0
11	Баруунбүрэн сумын соёлын төвд тоног төхөөрөмж, сандал авах	40.0
12	Сүхбаатар хөгжил тохижилт ОНӨААТҮГ-т сагстай өргөгч авах	25.0
13	Шаамар МСҮТ тоног төхөөрөмж авах	20.0
14	Шагайн холбоонд тоног төхөөрөмж	16.0
15	Самбо бөхийн дэвжээ авах	15.0
16	Чөлөөт бөхийн дэвжээ авах	15.0
17	Сэлэнгийн долгио чуулгад лед дэлгэц худалдан авах	50.0
18	Сүхбаатар хот тохижилт ОНӨААТҮГ-т ковш худалдан авах	150.0
19	Жудо бөхийн дэвжээ авах	20.0
20	Улсын бүртгэлийн хэлтэст машин авах	29.5
21	Сант сумын ЕБС-д хөдөлмөр амралтын зуслан байгуулах	50.0
22	Сайхан сумын хүчирхийллийн эсрэг төвийн их засвар	80.0
23	Сүхбаатар сумын Хуримын ордны хүчитгэх, засварын ажил	250.0
24	Баруунбүрэн сумын сургуулийн шалны засвар	71.4
25	Орхонтуул сумын Эрүүл мэндийн төвийн дээврийн их засвар	67.0
26	Түшиг сумын Эрүүл мэндийн төвийн дотор засвар	28.0
27	Хушаат сумын соёлын төвийн их засвар	100.0
28	Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн засвар	38.0
29	Цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, зүлэг арчилгаа	40.0
30	Шаамар сум Партизаны хөшөөт талбайн тохижилт, засвар	18.0
	Нийт дүн	2,801.5

Эх сурвалж: БИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэл, төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн жагсаалт

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын нийт 4,551.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төсөл, арга хэмжээнээс 3,254.1 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг ИТХ-

аар батлуулахаас өмнө хийлгэсэн бол 637.9 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг батлуулсны дараа хийлгэж, 584.5 сая төгрөгийн өртөг бүхий 14 төсөл, арга хэмжээг / 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй баяр наадмын зардал зураг, төсөв шаардлагагүй болно./, зураг, төсөв, тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29.4¹¹, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3¹² дахь заалтуудыг зөрчсөн байна. / Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т харуулав /

Тайлант онд улсын төсвийн байгууллагуудад их засвар хийх, тоног төхөөрөмж, автомашин худалдан авахад аймгийн болон Сайхан сумын ОНХС-аас нийт 6 төсөл, арга хэмжээнд 181.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.5¹³ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

Аймгийн ОНХС:

- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мэргэжлийн хяналтын газарт улаан буудайн шинжилгээний аппарат авах”,
- 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шаамар сумын МСҮТ-д тоног төхөөрөмж”,
- 29.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улсын бүртгэлийн хэлтэст автомашин авах”,
- 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн Нэгдсэн эмнэлэгт тархины цахилгаан бичлэгийн аппарат авах”,
- 38.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн засвар” зэрэг 5 төсөл, арга хэмжээнд нийт 172.5 сая төгрөгийг,

Сайхан сумын ОНХС: 8.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сум дундын нэгдсэн эмнэлэгт нярай хүүхдийн шарлагын аппарат худалдан авах”

Аймгийн Засаг дарга нь 283.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мандал суманд баригдаж буй 126 айлын орон сууцны барилгын гадна инженерийн шугам сүлжээ” төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын зээлээр хэрэгжүүлэхээр ТОСК ТӨҮГ-тай 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдөр 2015/4-9(а) дугаартай гэрээ байгуулсан боловч зээлийг гэрээний хугацаанд төлж барагдуулаагүйгээс шүүхийн шийдвэрийн дагуу 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр эвлэрлийн гэрээ байгуулж, 82.0 сая төгрөгийг ОНХС-ийн эх үүсвэрээр төлж барагдуулахаар төлөвлөсөн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зориулалт бус зардлуудыг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа нь нөөцийг үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг алдагдуулж байна.

¹¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

¹³ ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно: 4.2.5.Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал.

**Бүлэг
2**

ОНХС-ийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 65.8 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу арвилан хэмнэлттэй байхаар зохион байгуулсан уу.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль эрхийн актын хүрээнд зохион байгуулахгүй байгаа нь хөрөнгө нөөцийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг алдагдуулж байна.

Аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд шинээр хэрэгжүүлэх нийт 4,551.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төсөл, арга хэмжээ / 75.0 сая төгрөгийн 1 хөтөлбөр, арга хэмжээ ХАА-нд хамаарахгүй болно./-нээс 2,300.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 1,286.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, 28.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зөвлөх үйлчилгээний аргаар, 7.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар сонгон шалгаруулсан бол 854.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг хугацаа оройтсон гэх шалтгаанаар худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. / Дэлгэрэнгүйг Хавсралт 4-т харуулав /

ТБОНӨХБАҮХА тухай хууль болон Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу аймгийн ОНӨГ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа цахим системийг ашигласан байна.

Гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар зохион байгуулах “Үнэлгээний хороо”-г аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар, харьцуулалтын аргаар зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. Уг үнэлгээний хороо, ажлын хэсэгт томилогдсон 225 гишүүд нь / давхардсан тоогоор / Сангийн сайдын 2015 оны 330 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-ийг бөглөж, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

Захиалагч аймгийн ЗДТГ нь худалдан авах ажиллагааны “Үнэлгээний хороо” болон “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд аймгийн ИТХ-аас томилсон иргэнийг бус

тухайн иргэнтэй тохиролцсоны үндсэн дээр гишүүнээр томилсон байгаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 47.4¹⁴ дэх заалтыг зөрчсөн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлсэн дараах 9 төсөл, арга хэмжээний үнэлгээний хороо, ажлын хэсгийн зарим гишүүд үнэлгээний дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байгаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 47.8¹⁵ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг тодруулбал:

- 177.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сумын байруудын гэрэлтүүлэг”,
- 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан сумын Хүчирхийллийн эсрэг төвийн их засвар”,
- 78.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мандал сумын Түнхэл тосгоны цэцэрлэгийн засвар”,
- 71.4 сая төгрөгийн төсөв өртөгтэй “Баруунбүрэн сумын сургуулийн шалны засвар”,
- 67.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орхонтуул сумын Эрүүл мэндийн төвийн дээврийн их засвар”.
- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сант сумын ерөнхий боловсролын сургуульд хөдөлмөр амралтын зуслан байгуулах”,
- 37.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Түшиг суманд хүүхдийн тоглоомын талбай байгуулах”,
- 24.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шаамар суманд ундны усны худаг гаргах”,
- 17.0 сая төгрөгийг төсөвт өртөгтэй “Сайхан сумын Номгон тосгоны Эрүүл мэндийн төвийн хүчитгэл”,

Тайлант онд 12 үнэлгээний хороо, 32 ажлын хэсэгт томилогдсон нийт 225 гишүүнээс 9 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1¹⁶ дэх заалтыг зөрчсөн байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох НТШ-ыг 2 удаа зохион байгуулж, нэг ч оролцогч санал ирүүлээгүй, шаардлага хангаагүй гэх үндэслэлээр 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Алтанбулаг сумын далангийн ажлын засвар” төсөл, арга хэмжээг Эко буянт ХХК-тай шууд гэрээ байгуулсан боловч захиалагч аймгийн ЗДТГ нь гэрээний хувь болон уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийг Сангийн яаманд хүргүүлээгүй байгаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 34.3¹⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

¹⁴ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

¹⁵ Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.

¹⁶ Энэ хуулийн 23.8-д заасан журмын дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

¹⁷ Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Аймгийн ОНӨГ нь цахим худалдан авах ажиллагааны архивын баримтад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж, хүлээн авсан баримт материалыг хавсаргаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 49.2¹⁸, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 8.2¹⁹ дахь заалтыг зөрчсөн байна.

Сумдууд: Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд шинээр хэрэгжүүлэх 2,945.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 108 төсөл, арга хэмжээнээс 729.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 1,239.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 505.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар зохион байгуулж, 470.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг хугацаа оройтсон гэх шалтгаанаар худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. / Дэлгэрэнгүйг Хавсралт 4-т харуулав /

Гүйцэтгэгчийг сонгох харьцуулалтын аргаас зайлсхийж Орхон, Орхонтуул сум нь ижил төстэй төсөл, арга хэмжээг 2 хувааж батлуулан, шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.4²⁰, 8.5²¹ дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Орхон сум “Бэлэндалай багийн Арбулангийн худаг”, “Бэлэндалай багийн Дэргээчийн худаг” ижил төсөл, арга хэмжээг 2 хувааж, тус бүрийг төсөвт өртгийг 10.0 сая төгрөгөөр,
- Орхонтуул сум “Рашаант тосгоны 7 байшингийн тохижилт”, “Рашаант тосгоны 7 байшинд автомашины зогсоол барих” төсөл, арга хэмжээг 2 хувааж, тус бүрийг 10.0 сая төгрөгөөр тус тус гүйцэтгүүлсэн.

Дараах сумд нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар сонгон шалгаруулахдаа тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэлээр зарлаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 21.1²² дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Баруунбүрэн сум 65.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Универсал трактор”,
- Ерөө сум 83.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хогны машин худалдаж авах /Буурагчин баг”,
- Мандал сум “Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгыг үргэлжлүүлэх”, “Хэрх, Түнхэл тосгонд асфальтан зам барих”, “1 дүгээр багийн вокзалын гудамжны замд хашлага, явган хүний зам хийх” зэрэг нийт 394.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ,

¹⁸ Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ: ... 49.2.10.гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан баримт бичиг.

¹⁹ Захиалагч хуулийн 49.2.1-49.2.9-д заасан баримт бичиг, материалыг тендер шалгаруулалтыг зохион байгуулж дууссанаар, хуулийн 49.2.10-т заасан баримт бичиг, гэрээг дүгнэж ажил, үйлчилгээг хүлээн авснаар зохих журмын дагуу архивлан хадгална.

²⁰ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

²¹ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

²² Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлана.

- Сайхан сум 83.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн паркийг тохижуулах, дугуйн зам байгуулах”,
- Цагааннуур сум 103.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төв доторх 2.53 км хатуу хучилттай замтай болох”.

Шаамар сум нь 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дэлгэрхаан 1 дүгээр баг Дэнжийн худгийг ухаалаг болгох” төсөл, арга хэмжээний тендерийн үнэлгээг ажлын хэсгийн гишүүдийн гарын үсгээр баталгаажуулаагүй бөгөөд дараах сумд нь цахим тендерийн баримт бичиг болон тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг цахим хэлбэрээр архивлаж, хадгалаагүй байгаа нь Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 8.3²³ дахь заалтыг зөрчсөн байна.

**Тендерийн баримт бичгийг цахим хэлбэрээр
архивлаагүй сумдын жагсаалт**

Хүснэгт 4 /сая төгрөг/

Д/д	Сумд	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Алтанбулаг сум	Гүний худаг 2 ширхэг	24.1
2		Ахмадын байр засварлах	20.4
3	Баруунбүрэн сум	Универсал трактор	65.0
4	Зүүнбүрэн сум	Төрийн үйлчилгээний нэг цэгийн байрны гаднах фасад засварлах	51.1
5	Орхон сум	Спорт заалны зураг төслийн ажил	16.6
6		Хогны машин худалдаж авах	30.0
7	Орхонтуул сум	Рашаант тосгонд явган хүний зам тавих/200метр/	15.0
8		Баянцогтын 2 дугаар багт 50 тн багтаамж бүхий зоорь барих	45.3
9	Түшиг сум	Цэцэрлэг гадна тоглоом	13.9
10		ЭМТ-ийн тоног төхөөрөмж	25.0
11	Хушаат сум	Даагат 1 дүгээр багийн гудамж талбайн гэрэлтүүлэг	20.0
12		Даагат 1 дүгээр багийн Бумбат тохойн айл өрхүүдийг эрчим хүчинд холбох шугам сүлжээний ажил	20.0
13		Цагаан идээ боловсруулах цехийн тоног төхөөрөмж худалдан авах	15.0
14	Шаамар сум	Дэлгэрхаан 1 дүгээр баг Дэнжийн худгийг ухаалаг болгох	25.0
15		Дулаанхаан тосгонд хүүхдийн тоглоомын талбай барих	34.9
Нийт дүн			421.3

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн ХАА-ны баримт, материал

Дээр дурдсанчлан ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгийг холбогдох хууль эрхийн актын хүрээнд зохион байгуулахгүй байгаа нь хөрөнгө нөөцийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг алдагдуулж байна.

2.2 Төлөвлөсөн төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанд нь бүрэн гүйцэтгүүлж, санхүүжилтийг олгосон уу.

²³ Захиалагч журмын 8.2-т зааснаар холбогдох баримт бичгийг архивлахдаа хуулийн 49.2.3, 49.2.5-д заасан материалыг цахим хэлбэрээр тусгай тээгч (зөөврийн хатуу диск, оптик диск) дээр архивлан хадгална.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 184 төсөл, арга хэмжээнээс 25.0 хувь нь огт хэрэгжээгүй бол 9.2 хувь нь дутуу хэрэгжсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд нийт 10,989.3 сая төгрөгийн / аймаг 7,483.2 сая төгрөг, сумд 3,506.1 сая төгрөг / төсөвт өртөгтэй 189 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 5,503.0 сая төгрөгийн өртөгтэй 121 төсөл, арга хэмжээ бүрэн, 1,899.3 сая төгрөгийн өртөгтэй 17 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 2,107.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 46 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй, 1,480.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй он дамжин хэрэгжих 5 төсөл, арга хэмжээ байна. / Дэлгэрэнгүйг Хавсралт 5-8-д харуулав /

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс зураг, төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийгдээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, батлагдсан төсөвт өртгөөр хэрэгжүүлэх боломжгүй зэрэг шалтгаанаар 1,309.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй бол ковид-19 цар тахал өвчний улмаас гүйцэтгэгчээс шалтгаалан дутуу хэрэгжсэн 1,532.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ байна. / Дэлгэрэнгүйг Хавсралт 7, 8-д харуулав /

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнээс зураг, төсөв нь хийгдээгүй, батлагдсан төсөвт өртгөөр хэрэгжүүлэх боломжгүй зэрэг шалтгаанаар 797.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй бол худалдан авах ажиллагааны хугацаа оройтож зарлагдсан, ковид-19 цар тахал өвчний улмаас дутуу хэрэгжсэн 366.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ байна. / Дэлгэрэнгүйг Хавсралт 7, 8-д харуулав /

Сайхан, Түшиг сумын ЗДТГ нь төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээнд гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг тусгалгүйгээр бүрэн бус гэрээ байгуулсан нь Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”-ийн “5 дугаар бүлэг Гэрээний ерөнхий нөхцөл, 6 дугаар бүлэг Гэрээний тусгай нөхцөл” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хүдэр сум нь төсөл, арга хэмжээний зураг, төсвийг актаар хүлээж аваагүй байхад зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч Ноёдын туурь ХХК-д 8.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 12.6²⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Ерөө, Сүхбаатар сумд нь 5 төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанаас 52-165 хоногоор хэтрүүлж хүлээлгэн өгсөн атал гэрээний дагуу 9.6 сая төгрөгийн алданги

²⁴ Зөвлөх үйлчилгээний зардлыг олгох санхүүжилтийн материалд гэрээний эх хувь, зохиогчийн хяналтын зардал өгөх тохиолдолд зохиогчийн хяналтын гэрээ, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөв тус бүрийн эх хувь эсхүл хуулбар, хүлээн авсан акт заавал хавсаргана.

тооцоогүй байгаа нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний “Тусгай нөхцөл”-ийн 14 дэх заалтыг зөрчсөн байна.

Алданги тооцоогүй төсөл, арга хэмжээ

Хүснэгт 5 /сая төгрөг/

Д/д	Сумд	Төсөл, арга хэмжээ	Гэрээний дүн	Хугацаа хэтрүүлсэн хоног	Алдангийн дүн
1	Ерөө сум	Тавин багийн гэрэлтүүлэг	47.9	106	2.5
2		Гудамжны гэрэлтүүлэг /Буурагчин баг/	15.7	61	0.5
3		Гудамжны гэрэлтүүлэг /Бугант баг/	44.7	165	3.7
4	Сүхбаатар сум	Сити нойл барих	46.7	108	2.6
5		8 дугаар багт гүний худаг гаргах	10.0	52	0.3
Нийт дүн			165.0		9.6

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн санхүүжилтийн баримт, материал

Цагааннуур сум нь 102.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төв доторх 2.53 км хатуу хучилттай замтай болох” төсөл, арга хэмжээний чанарын баталгаа 5.1 сая төгрөгийг суутгаж, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байгаа нь гэрээний тусгай нөхцөлийн 15 дахь “Гүйцэтгэлийн баталгаа гэрээний дүнгийн 5 хувь” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулалгүйгээр аймгийн ОНХС-гаас 27.6 сая төгрөг, дараах 8 сум 6.2 төгрөг олгосон нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.16²⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

Магадалшгүй ажлын зардлыг бүрдэл дутуу баримтаар олгосон төсөл, арга хэмжээ

Хүснэгт 6 /сая төгрөг/

Д/д	Сумд	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Магадалшгүй ажлын			
				Дүн	Тэмдэглэл	Акт	Зураг төсөв
1	Баянгол сум	Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг	50.0	0.8	2020.06.15	2020.06.15	Үгүй
2	Ерөө сум	Гангад гэрэлтүүлэг тавих	15.3	0.3	-	2020.04.25	Тийм
3		Гудамжны гэрэлтүүлэг /Буурагчин баг/	16.0	0.3	-	2020.08.20	Тийм
4		Гүний худаг гаргах /Буурагчин баг/	17.0	0.3	-	2020.10.10	Тийм
5	Мандал сум	Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгыг үргэлжлүүлэх	200.0	3.2	2020.07.29	2020.07.29	Үгүй
6	Орхонтуул сум	Атар-60 жилд зориулсан хүндэтгэлийн талбай барих	18.4	0.6	-	2020.10.19	Үгүй

²⁵ Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөвт тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.

7	Түшиг сум	Эрүүл мэндийн төвийн засвар	7.0	0.1	-	2020.11.06	Үгүй
8	Шаамар сум	Дэлгэрхаан 1 дүгээр баг Дэнжийн худгийг ухаалаг болгох	35.0	0.6	-	2020.10.14	Тийм
Нийт дүн			2,169.4	6.2			

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн санхүүжилтийн баримт, материал

Сайхан сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гүний худаг 2 ширхэг” төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй бол Орхон сумын ЗДТГ нь 29.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хогны машины тээврийн хэрэгслийг байгууллагын эзэмшилд шилжүүлж бүртгээгүй байгаа нь хөрөнгө үрэгдэн шамшигдах эрсдэлийг үүсгэж байна.

2.3 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад үр нөлөө бүхий хяналт, шалгалт хийгдсэн үү.

Эрх бүхий байгууллагуудаас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд үр нөлөө бүхий хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, авто машин худалдан авах зэрэг 430.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээний хэрэгжилт болон сумд нь нийт 500.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээний ажлын явц, гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээ

Хүснэгт 7 /сая төгрөг/

Д/д	Сумд	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Аймгийн ОНХС	Мэргэжлийн хяналтын газарт улаан буудайн шинжилгээний аппарат авах	50.0
2		Нэгдсэн эмнэлэгт тархины цахилгаан бичлэгийн аппарат авах	35.0
3		Алтанбулаг суманд хогны машин авах	40.0
4		Баруунбүрэн сумын соёлын төвд тоног төхөөрөмж, сандал авах	40.0
5		Шаамар МСҮТ тоног төхөөрөмж авах	20.0
6		Шагайн холбоонд тоног төхөөрөмж	16.0
7		Сэлэнгийн долгио чуулгад лед дэлгэц худалдан авах	50.0
8		Сүхбаатар хот тохижилт ОНӨААТҮГ-т ковш худалдан авах	150.0
9		Улсын бүртгэлийн хэлтэст автомашин авах	29.5
10	Баруунбүрэн сум	Ухаалаг худаг	10.0
11	Баянгол сум	Тоглоомын талбай сайжруулах	20.0
12	Жавхлант сум	Ундны усыг зөөлрүүлэх, цэвэршүүлэх	19.4
13		Халуун усны байр засварлах	30.0
14		Сумын төвийг камержуулах	33.1
15	Мандал сум	2 дугаар багт гүний худаг шинээр барьж, ухаалаг худгийн систем суурилуулах	30.0
16		1, 6 дугаар багт 4 худгийг засварлаж, ухаалаг худгийн систем суурилуулах	80.0
17		Гэрэлтүүлэг засварлах	50.0

18	Сайхан сум	Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /Номгон тосгон/	40.0
19		Хөтөл хотыг камержуулах	30.0
20		Гүний худаг 2 ширхэг	20.0
21	Орхонтуул сум	Атар-60 жилд зориулсан хүндэтгэлийн талбай барих	18.4
22	Цагааннуур сум	Зам даваа засах	20.0
23	Хушаат сум	Даагат 1 дугаар багийн гудамж талбайн гэрэлтүүлэг	20.0
24		Даагат 1 дугаар багийн Бумбат тохойн айл өрхүүдийг эрчим хүчинд холбох шугам сүлжээний ажил	20.0
25	Шаамар сум	Дэлгэрхаан 1 дугаар баг Дэнжийн худгийг ухаалаг болгох	25.0
26		Дулаанхаан тосгонд хүүхдийн тоглоомын талбай барих	35.0
Нийт дүн			931.4

Эх сурвалж: Сумдын ОНХС-ийн санхүүжилтийн баримт, материал

Мандал, Сайхан, Сүхбаатар, Хушаат, Шаамар сумд нийт 195.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 6 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зураг, төсөв зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Мандал сум 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “2 дугаар багт гүний худаг шинээр барьж, ухаалаг худгийн систем суурилуулах”, 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “1, 6 дугаар багт 4 худгийг засварлаж, ухаалаг худгийн систем суурилуулах”,
- Сайхан сум 30.0 сая төгрөгийн төсөв өртөгтэй “Хөтөл хотыг камержуулах”,
- Сүхбаатар сум 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “8 дугаар багт гүний худаг гаргах”,
- Хушаат сум 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Даагат 1 дүгээр багийн гудамж талбайн гэрэлтүүлэг”,
- Шаамар сум 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Дэлгэрхаан 1 дүгээр баг “Дэнжийн худгийг ухаалаг болгох”

Тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад болон хэрэгжилтэд аймгийн ИТХ-ын дэргэдэх Эдийн засаг, төсвийн бодлогын хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаас хяналт, шалгалт огт хийгдээгүй байна.

Мөн Жавхлант, Сайхан, Сүхбаатар, Шаамар сумдын ИТХ-ын дэргэдэх хороод нь ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавиагүй байгаа Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9.4²⁶ дэх заалтыг зөрчсөн байна.

²⁶ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

Сумдын ИТХ-ын дэргэдэх хорооноос хийсэн хяналт шалгалтаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг багийн ИНХ-аар хэлэлцэн шийдвэрлэсэн, иргэдийн санал авч, эрэмбэлэгдсэн байдал, зураг, төсөв, тооцоо, судалгаа нь урьдчилан хийгдсэн эсэх, худалдан авах ажиллагаа зэрэг эрсдэлтэй асуудлуудыг хамруулж авч үзээгүй байна.

Дээрх 4 сумдаас бусад ИТХ-ын дэргэдэх хороод нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний чанар байдалтай танилцаж, зөвлөмж өгсөн гэх боловч үр дүнг ИТХ-аар хэлэлцэж, тухайн төсөл, арга хэмжээний нийгэмд хүртээх үр өгөөжийг тооцоогүй зэрэг нь хяналт шалгалт үр нөлөө муутай хийгдсэнийг харуулж байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймаг, сумдын ОНХС-ийн 2020 оны үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй бөгөөд шат шатны ЗДТГ нь аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 9.5²⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд холбогдох байгууллагуудын зүгээс хяналт шалгалт хийдэггүй, үр дүнг үнэлдэггүй зөрчил давтагдан гарсан байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар аймаг, сумдын дүнгээр нийт **5,655.0 сая төгрөгийн / 1 төсөл арга хэмжээний давхардсан зөрчлийг хасаж тооцсон / зөрчил илэрч, албан шаардлага хүргүүлээ. / Дэлгэрэнгүйг хавсралт 9-д харуулав / Үүнд:**

Аймгийн ОНХС: / 3,366.4 сая төгрөгийн зөрчил /

- Шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад "Сайхны хөтлийн шилэн гүүрний суурийн ажил"-ын 2020 оны санхүүжилтийг "0" дүнтэйгээр буюу хэрэгжихгүй төсөл, арга хэмжээг тусгасан бол 1 төсөл, арга хэмжээ буюу "Шаамар сумын Партизаны талбайн тохижилт, засварын ажил" –ыг тус бүр 18.0 сая, 19.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр давхардуулан төлөвлөсөн,
- Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт **1,932.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн,**

²⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ.

- Барилга угсралт, их засварын ажлын зураг, төсөв, тавилга, тоног төхөөрөмжийн үнийн тооцоо судалгаагүйгээр 11 төсөл, арга хэмжээнд **470.0 сая төгрөгийг** зарцуулахаар төлөвлөсөн,
- Нийт **637.9 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг ИТХ-аар батлуулсны дараа гүйцэтгүүлсэн,
- Улсын төсвийн байгууллагуудад их засвар хийх, тоног төхөөрөмж, автомашин худалдан авах зэрэг 5 төсөл, арга хэмжээнд 172.5 сая төгрөг, “Атрын 60 жилийн ойн арга хэмжээний зардал”-д 120.0 сая төгрөг, “Шагайн холбоонд тоног төхөөрөмж авах”-д 16.0 сая төгрөг зэрэг нийт **308.5 сая төгрөгийг** зориулалт бусаар зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Сумдын ОНХС: / нийт 2,288.6 сая төгрөгийн зөрчил /

- Барилга угсралт, их засварын ажлын зураг, төсөв, тавилга, тоног төхөөрөмжийн үнийн тооцоо судалгаагүйгээр 12 сум нийт **740.7 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй 30 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн,
- 12 сум нийт **1,457.9 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг ИТХ-аар батлуулсны дараа хийлгэсэн,
- Алтанбулаг, Цагааннуур сум нь ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт **11.6 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг тусгаж, төлөвлөсөн,
- Сүхбаатар, Хүдэр, Түшиг сумд нь орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардалд 11.5 сая төгрөг, Сайхан сум нь улсын төсөвт сум дундын нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж худалдан авахад 8.5 сая төгрөг зэрэг нийт **20.0 сая төгрөгийг** зориулалт бусаар зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн,
- Орхон, Орхонтуул сумд нь нийт **40.0 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаас зайлсхийх зорилгоор төсөвт өртгийг 2 хуваан төлөвлөж, худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн,
- Хүдэр сум нь **8.8 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй “Зураг төсөв хийлгэх” ажлыг комиссын актаар хүлээж аваагүй байхад санхүүжилтийг гүйцэтгэгчид бүрэн олгосон,
- Ерөө, Сүхбаатар сумд нь 5 төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанаас 52-165 хоногоор хэтрүүлж хүлээлгэн өгсөн атал гэрээний дагуу **9.6 сая төгрөгийн** алданги тооцоогүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Түшиг сумаас бусад сумд нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор гадаад, дотоодын аж ахуйн нэгжээс өгөх хандив, тусламжийн орлогыг тооцож, төлөвлөөгүй бөгөөд Мандал сум нь гадаадын хандив тусламжийг төрийн бус байгууллагын дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

2. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдээс санал аваагүй, зураг, төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь нөөцийг үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй зарцуулж, хуваарилах нөхцөлийг алдагдуулж байна.
4. ОНХС-ийн хөрөнгийг улсын төсвийн болон ТББ-д автомашин, тоног төхөөрөмж худалдан авах, удирдлагын үйл ажиллагааг санхүүжүүлэх зэргээр зориулалт бусаар зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
5. ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг холбогдох хууль эрхийн актын хүрээнд зохион байгуулахгүй байгаа нь хөрөнгө нөөцийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг алдагдуулж байна.
6. Зарим сумд нь харьцуулалтын аргаас зайлсхийж төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулсан байна.
7. ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 65.8 хувь нь бүрэн, 9.2 хувь нь дутуу хэрэгжсэн бол 25.0 хувь нь огт хэрэгжээгүй байна.
8. Аймгийн ИТХ-ын дэргэдэх хороо болон ТЕЗ-ийн дотоод аудитаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийгээгүй байна.
9. Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.
10. Зарим сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Иргэдийн санал авсан, зураг төсөв, тооцоо судалгаа, магадлал хийгдсэн төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, батлах.
2. ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ИТХ-аас хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулж, үр дүнг хэлэлцэж, шийдвэрлэж байх.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламжийн орлогыг ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт төлөвлөж, холбогдох хууль, журмын дагуу зарцуулж байх.

2. Иргэдийн саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулж, эрэмбэлсний үндсэн дээр урьдчилсан жагсаалтыг бэлтгэн, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэх.
3. ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн олон тооны төсөл, арга хэмжээг бус орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын ажлуудад зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөж, ИТХ-аар батлуулах.
4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, үр дүнг хэлэлцэн, шийдвэрлэж байх.

Аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нарт:

1. Төсөл, арга хэмжээний чанарын баталгааг гэрээнд тусгасны дагуу суутгаж, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулж байх.
2. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцох.
3. Төсөл, арга хэмжээний / ялангуяа тоног төхөөрөмж, машин техник худалдан авах / хэрэгжилтэд захиалагчийн болон зураг, төсөв зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж байх.
4. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл, тайланд бүрэн тусган , төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж байх.
5. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, баримт материалын бүрдлийг хангуулж, архивлаж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
С.БААСАНСҮРЭН

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХОХБТХ-ЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: 7036-3834

2021.07.06 № 02/724
танай _____-ны № _____

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА  Ө.СУВДАА



C:user/albanbichig2021/jijig tootA5

· 430811220

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр ашиг, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх тайлбар

№	Зөвлөмжийн нэр	Тайлбар
Аймаг, сумдын Засаг дарга нарт		
1	ОНХС-ийн эх үүсвэрт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс үзүүлж буй хандив, тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлэхээр төлөвлөж, холбогдох хууль, журмын дагуу зарцуулж байх.	ОНХС-ийн үйл ажиллагааны журмын дагуу аж ахуйн нэгжүүдээс үзүүлж буй хандив, тусламжийн орлого Болд Төмөр Ерөө ХХК-иас “Сайхны хөтөл орчмын шилэн гүүр”-ний хандивт олгосон 700,0 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн 100130052400 тоот дансанд төвлөрүүлээд байна. Цаашид уул уурхайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс орсон хандив тусламжийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлж ажиллана.
2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан иргэдийн оролцоог хангаж ажиллах.	2021 онд дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын улмаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах ажил хойшлогдож цахим хэлбэрээр зохион байгууллаа. Цаашид “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу аймаг сумдын хэмжээнд нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллах болно.
3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хэт жижиглэсэн олон тооны төсөл, арга хэмжээг бус орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөж, ИТХ-аар батлуулах	ОНХС-ийн хөрөнгөөр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгох урт хугацаанд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг эхлүүлэхээр аймгийн ИТХ-аар батлуулаад байна. Цаашид хэт жижиглэсэн олон тооны төсөл, арга хэмжээг бус орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий томоохон хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөж, тусгуулсан.
4	ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зарцуулалтад үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, үр дүнг хэлэлцэн, шийдвэрлэж байх	Аймаг болон сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн хагас жилийн хяналт-шинжилгээний тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. Зөвлөмжийн хүрээнд 2021 оны ОНХС-гийн хөрөнгө оруулалтын явцын хэрэгжилтэд Санхүүгийн хяналт аудитын алба болон Хяналт –шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран дотоод хяналт, шалгалт хийлгэж дүгнэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Сумдын ОНХС-ийн хагас жилийн хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр нэгтгэн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
Аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нарт		

1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засаг даргын зөвлөлд танилцуулан хэрэгжүүлж байх	Зөвлөмжийн дагуу 2021 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтын явц, хэрэгжилтэд Санхүүгийн хяналт аудитын алба болон Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран дотоод хяналт, шалгалт хийлгэж, дүгнэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Сумдын ОНХС-ийн хагас жилийн хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр нэгтгэн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
2	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж байх	ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.2-т заасны дагуу Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ" гэж заасны дагуу сумдаас ОНХС-ийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг нэгтгэн ажиллаж байна.
3	Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу /цахимаар/ зохион байгуулах, баримт материалыг бүрэн бүрдүүлж, архивлан хадгалж байх	2020 оны хөрөнгө оруулалтын гэрээ, хүлээн авсан комиссын акт зэрэг тендерийн хавсралт хэргийн баримтыг бүрэн бүрдүүлж, архивт өгч ажиллаж байна. Орон нутгийн өмчийн газар болон сумдад худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу /цахимаар/ зохион байгуулахаар, талаар тайлан мэдээг ирүүлж ажиллах талаар албан тоотоор болон цахим сургалт хэлбэрээр үүрэг чиглэл өгч ажилласан.
4	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж, гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутам алданги тооцох	Аймгийн хэмжээнд Улсын болон орон нутгийн төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 131 ажлын гэрээг байгуулан ажилласан. 2020 онд 11 ажилд 9,6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн хоногийн алданги тооцон аймгийн төсөвт төвлөрүүлсэн.
5	ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл, тайланд бүрэн тусгах	2021 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжүүлсэн ажил, төсөл, арга хэмжээг өмчид бүртгэсэн тухай ашиглагчийн тодорхойлолтыг үндэслэн 100 хувийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ӨГСӨН ТАЙЛБАР

Захиалагч аймгийн ЗДТГ нь аудитын тайлангийн төсөлд тусгагдсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, цаашид арилгаж, давтан гаргахгүй ажиллах тухай албан бичиг ирүүлсэн тул аудитын тайлангийн төсөлд засвар хийгдэх шаардлагагүй гэж үзлээ.

Аймаг, сумдын ОНХС-ийн 2020 оны хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт

Д/д	Санхүүжилт олгох аймаг, сумд	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан				Тогтвортой амьжиргаа 3 төслөөс		Орлогын шилжүүлгийн дүн	ОНХС-ийн эхний үлдэгдэл	Аж ахуйн нэгжүүдийн хандивын орлого	Нийт санхүүжилтийн дүн
		Сумын ОНХС				Урамшуулал	Дэмжлэг				
		Хүн ам 40%	Алслалт 30%	Нутаг дэвсгэр 30%	Суурь зарлага						
1	Алтанбулаг сум	36.9	5.4	30.9		17.2	10.8	101.2	0.02		101.2
2	Баруунбүрэн сум	23.3	31.1	41.3		22.2	14.1	132.0	45.0		177.0
3	Баянгол сум	41.2	43.6	29.0		26.4	16.7	156.9	87.6		244.5
4	Ерөө сум	50.6	27.5	120.5		45.7	28.9	273.2	92.1		365.3
5	Жавхлантаг сум	14.3	5.7	17.5		9.2	5.8	52.5	35.0		87.5
6	Зүүнбүрэн сум	21.2	5.7	17.7			6.5	51.1	6.0		57.1
7	Мандал сум	200.9	279.8	71.1	77.3	126.8	80.6	836.5	52.1		888.6
8	Орхон сум	17.5	18.6	19.2		12.7	8.1	76.1	0.5		76.6
9	Орхонтуул сум	27.9	40.6	43.2		25.7	16.3	153.7	55.9		209.6
10	Сайхан сум	69.5	67.3	19.3	38.9	36.0	22.8	253.8	11.8		265.6
11	Сант сум	15.8	18.2	20.3		12.0	8.1	74.4	2.8		77.2
12	Сүхбаатар сум	170.8		0.7	25.1		24.9	221.5	7.6		229.1
13	Түшиг сум	13.5	11.1	36.6		12.9	9.3	83.4	32.6	145.0	261.0
14	Хушаат сум	19.9	10.7	29.5			7.6	67.7	4.0		71.7
15	Хүдэр сум	14.9	14.8	41.7		17.9	11.4	100.7	0.8		101.5
16	Цагааннуур сум	37.5	20.4	56.0		26.2	16.6	156.7	1.7		158.4
17	Шамар сум	30.1	3.9	9.9		9.8	6.2	59.9	0.1		60.0
	Сумдын ОНХС	805.8	604.4	604.4	141.3	400.7	294.7	2,851.4	435.6	145.0	3,431.9
18	Аймгийн ОНХС				341.2			4,888.1	201.4	700.0	5,789.5
	Нийт дүн	805.8	604.4	604.4	482.5	400.7	294.7	7,739.5	637.0	845.0	9,221.4

Хавсралт 1
/сая.төгрөг/
МН 40065 365436

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын ажлын зураг, төсвийг ИТХ-аар батлагдсаны дараа хийсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая.төгрөг/

Д/д	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хугацаа		Төсөвт өртөг
		Эхлэх	Дуусах	
Алтанбулаг сум				
1	Хүүхдийн тоглоомын талбай шинээр хашаа барих	2020	2020	20.0
2	Гүний худаг 2 ширхэг	2020	2020	24.1
3	Ахмадын байр засварлах	2020	2020	20.4
Баянгол сум				
4	Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг	2020	2020	50.0
5	Худаг шинээр гаргах	2020	2020	40.0
6	Тоглоомын талбай сайжруулах	2020	2020	20.0
7	Үерийн далан сувгийн ажил	2020	2020	30.0
8	Гонир багт явган хүний зам хийх	2020	2020	16.8
Ерөө сум				
9	Тавин багийн гэрэлтүүлэг	2020	2020	48.0
10	Гудамжны гэрэлтүүлэг /Буурагчин баг/	2020	2020	16.0
11	Гүний худаг гаргах /Буурагчин баг/	2020	2020	17.0
12	Гудамжны гэрэлтүүлэг /Бугант баг/	2020	2020	50.0
Жавхлант сум				
13	Ундны усыг зөөлрүүлэх,цэвэршүүлэх	2020	2020	19.4
14	Халуун усны байр засварлах	2020	2020	30.0
Зүүнбүрэн сум				
15	Төрийн үйлчилгээний нэг цэгийн байрны гаднах фасад засварлах	2020	2020	51.1
Мандал сум				
16	1 дүгээр багийн вокзалын гудамжны замд хашлага, явган хүний зам хийх	2020	2020	94.4
17	Хэрх, Түнхэл тосгонд асфальтан зам барих	2020	2021	100.0
18	Гэр хорооллын гудамжны хайрган хучилттай замуудыг засварлах	2020	2020	50.0
19	Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгыг үргэлжлүүлэх	2020	2020	200.0
Орхон сум				
20	Бэлэндалай багийн Арбулангийн худаг	2020	2020	10.0
21	Бэлэндалайн багийн Дэргээчийн худаг	2020	2020	10.0
Сайхан сум				
22	Хүүхдийн паркыг тохижуулах, дугуйн зам байгуулах	2020	2020	83.5
Сүхбаатар сум				
23	Сити нойл барих	2020	2020	47.4
24	Буур хээрийн 8 дугаар багт тоглоомын талбай барих	2020	2020	28.0
25	5 дугаар багт гэрэлтүүлэг	2020	2020	7.6
26	1 дүгээр багийн хүүхдийн тоглоомын талбай тохижуулах	2020	2020	10.0
27	5 дугаар багт хүүхдийн тоглоомын талбай барих	2020	2020	28.0
28	4 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай барих	2020	2020	28.0
Түшиг сум				
29	Сумын төвийн дулааны шугамын их засвар	2020	2020	150.0
Хушаат сум				
30	Даагат 1 дүгээр багийн Бумбат тохойн айл өрхүүдийг эрчим хүчинд холбох шугам сүлжээний ажил	2020	2020	20.0
Цагааннуур сум				
31	Зам даваа засах	2020	2020	20.0
32	Сумын төв доторх 2.53 км хатуу хучилттай замтай болох	2020	2020	103.1
Шаамар сум				
33	Дулаанхаан тосгонд хүүхдийн тоглоомын талбай барих	2020	2020	35.0
Нийт дүн				1,477.9

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын ажлын зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй болон зураг, төсвийг ИТХ-аар батлагдсаны дараа хийсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая.төгрөг/

Д/д	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хугацаа		Төсөвт өртөг
		Эхлэх	Дуусах	
Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээ				
1	Орхонтуул сумын Рашаант тосгонд дулааны шугам тавих	2020	2020	50.0
2	Сант сумын Эрүүл мэндийн төвийн ажилчдын байрны цэвэр бохир шугам шинээр татах	2020	2020	15.0
3	Мэргэжлийн хяналтын газарт улаанбуудайн шинжилгээний аппарат авах	2020	2020	50.0
4	Нэгдсэн эмнэлэгт тархины цахилгаан бичлэгийн аппарат авах	2020	2020	35.0
5	Алтанбулаг суманд хогны машин авах	2020	2020	40.0
6	Баруунбүрэн сумын соёлын төвд тоног төхөөрөмж, сандал авах	2020	2020	40.0
